

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 11 дүгээр сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 11 дүгээр сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	/тоогоор/			
		2011-9 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-10 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	162	4 ¹		166
3	Даатгалын төлөөлөгч	2091	27 ²		2118
4	Даатгалын зуучлагч	8			8
5	Даатгалын хохирол үнэлэгч	8	1 ³		9
6	Актуарч	12	1 ⁴		13
7	Бусад		1 ⁵		1

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, даатгалын компанийн салбарын тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 180 дугаар тушаалаар “Номин даатгал” ХХК-д Баян-Өлгий, Завхан аймагт салбар, Хорооны даргын 2011 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 178 дугаар тушаалаар “Миг даатгал” ХХК-д Чингэлтэй дүүргийн 6-р хороо, Баянгол дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт салбар нээн ажиллуулахыг тус тус зөвшөөрсөн;

²Хорооны даргын 2011 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 173 дугаар тушаалаар 9 иргэнд “Практикал даатгал” ХХК-ийн, Хорооны даргын 2011 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 184 дүгээр тушаалаар 3 иргэнд “Ган зам даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон;

³ Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 330 дугаар тогтоолоор “Арвижих эстимэйт ” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл олгосон, Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 328 дугаар тогтоолоор “Мега марз” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг 1 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн.

⁴ Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 329 дүгээр тогтоолоор Д. Нарангэрэлд ердийн даатгалын актуарийн эрх олгосон.

⁵Хорооны 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 303 дугаар тогтоолоор “Практикал даатгал” ХХК-д барилга угсралтын даатгал хэлбэрийн зөвшөөрөл нэмж олгосон.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2011 оны 11 дүгээр сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 11 дүгээр сарынхтай харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгээр/	
		2010-XI	2011-XI
1	Даатгалын нийт хураамж	3 020 334 012.9	2 643 438 812.37
2	Олгосон нийт нөхөн төлбөр	356 415 489.8	1 212 452 393.50
3	Давхар даатгалд төлсөн хураамж	15 727 860.0	399 866 717.00
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	7 072	7,768
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	60 023 500 000.0	45 727 712 336.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	73 371 229.0	229 100 074.00

2011 оны 11 дүгээр сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 376.9 сая төгрөгөөр буурч, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 856.1 сая төгрөгөөр, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 384.1 сая төгрөгөөр тус тус өсчээ.

2011 оны 11 дүгээр сард “Гэр даатгал” ХХК шинээр даатгалын гэрээ байгуулаагүй, даатгалын хураамжийн орлого болон, даатгалын нөхөн төлбөргүй ажилласан байна.

Ердийн даатгалын компаниудын 2011 оны 11 дүгээр сард байгуулсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Мандал женерал даатгал” ХХК-ийн 45727.7 сая төгрөгийн үнэлгээтэй гэрээ байсан бол хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр болох 70.6 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-11 сар	2011-11 сар
1	Даатгалын нийт хураамж	90 189 770.6	216 092 148.73
2	Олгосон нийт нөхөн төлбөр	5 934 352.5	8 201 655.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	28 977 694.79
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	11	27
	Үүнээс:-Хувь хүний хугацаат даатгалд	10	3
	-Байгууллагын хугацаат даатгалд	1	8
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д	-	2

	-Эмнэлгийн мөнгөний даатгалд	-	10
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		2
	-Тэтгэврийн даатгалд		2
	-Орон сууцны даатгалд		
	-Хуримтлалын даатгалд		
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	15 000 000.0	401 772 000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	2 000 000.0	2 044 098.00

Урт хугацааны даатгалын компанийн 2011 оны 11 дүгээр сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны 11 дүгээр сартай харьцуулбал даатгалын хураамжийн орлого 125.9 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 2.3 сая төгрөгөөр, давхар даатгалын хураамж 28.9 сая төгрөгөөр, тус тус өсч, хамгийн өндөр үнэлгээтэй гэрээ нь 401.7 сая төгрөг, хамгийн их нөхөн төлбөр 2.1 сая төгрөг байсан байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-10 сар	2011-11 сар	Өсөлт бууралт
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	30 926 510.7	88 316 260.12	57 389 750.00
2	Даатгалын зуучлагчийн орлого	18 908 904.7	28 347 990.37	9 439 086.33
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	33	-	-33
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	6,420,350,000.0	3 530 345 878.00	-2 890 004 122

2011 оны 11 дүгээр сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 88.3 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна. Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр үнэлгээний дүнтэй даатгалын гэрээ буюу 80.6 сая төгрөгийн гэрээг “Ачит ундарга” ХХК зуучлан борлуулсан байна.

Тайлант хугацаанд “Монголиан интернэшнл брокерс” ХХК даатгалын зуучлалын орлогогүй ажилласан байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-10 сар	2011- 11 сар	Өөрчлөлт
1	Даатгалын хохирол үнэлсэн орлого	5 860 636.4	7 631 900.00	1 771 263.6
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	294	334	40
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн	17 225 000.0	73 383 000.00	56 158 000.00

өндөр хохирлын дүн			
--------------------	--	--	--

2011 оны 11 дүгээр сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 334 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж 7.6 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Тайлант хугацаанд “Файн эстимэйт” ХХК даатгалын хохирол үнэлсэн орлогогүй байна.

3. БУСАД

2011 оны 11 дүгээр сард Хорооны даргын баталсан удирдамжийн дагуу “Жонон даатгал” ХХК, “Ачит ундарга” ХХК-ийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийсэн.

Мэдээг хянасан:

Даатгалын газрын дарга

С.Ганболд

БТХ-ийн дарга

П. Цэрэндэжид

Мэдээ гаргасан:

Даатгалын газрын хянан шалгагч

Э. Эрдэнэтуяа /2011.12.23/